



ДУНГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2013 оны 06 сарын 13 өдөр

Дугаар 79

Мандалговь 19

Нийтлэг үйлчилгээ үйлдвэрийн
газар байгуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.3 ж, 18.1.3.А, 18.1.3.Н заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2.4, 77.4 дэх заалтуудыг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийтлэг үйлчилгээний албаны үйл ажиллагааг өөрчлөлгүйгээр төрийн байгууллагад чанартай үйлчилгээ үзүүлэх үүрэг бүхий орон нутгийн өмчит Нийтлэг үйлчилгээ үйлдвэрийн газар байгуулсугай.

2. Орон нутгийн өмчит Нийтлэг үйлчилгээ үйлдвэрийн газрын дүрмийг нэгдүгээр хавсралтаар, үлгэрчилсэн бүтцийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Орон нутгийн өмчит Нийтлэг үйлчилгээний газрын ажлын үр дүн, тайланг жил бүр аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдэд тайлагнаж байхыг Аймгийн Засаг дарга С.Сүхбаатарт даалгасугай.

ДАРГА

С.БУДЖАВ

070500114

ОРОН НУТГИЙН ӨМЧИТ “НИЙТЛЭГ ҮЙЛЧИЛГЭЭ” ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН ДҮРЭМ

Зорилго: Аймгийн төр, захиргааны болон төсөвт албан газар байгууллагад өртөг зардал багатай чанартай нийтлэг үйлчилгээ үзүүлж, тэдгээр байгууллагууд үйл ажиллагаагаа хэвийн жигд явуулах нөхцөл бололцоогоор хангах явдал юм.

Нэг Нийтлэг үндэслэл

1.Төрийн үйлчилгээний газрын оноосон нэр: Орон нутгийн өмчит “Нийтлэг үйлчилгээ” үйлдвэрийн газар

а.Товчилсон нэр ОНӨНҮҮГ

б.Газрын оршин байгаа хаяг: Дундговь аймгийн Мандалговь хот

2.Өмчлөгч нь Дундговь аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал байна.

100% орон нутгийн өмчтэй үйлдвэрийн газар байна.

3.ОНӨНҮҮГ нь аймгийн Засаг дарга түүний Тамгын газар, Иргэдийн төлөөлөгчдийн хурал, төсвөөс санхүүждэг зарим байгууллагууд /цаашид үйлчлүүлэгч байгууллагууд гэнэ/-ын үйлчилгээ аж ахуйн ажлыг эрхлэн тэдгээрийн хөрөнгө санхүүгийн нийтлэг нөөцийг уялдуулан зохицуулах чиг үүрэг бүхий аймгийн Засаг даргын эрхэлсэн ажлын хүрээнд ажиллах төрийн төсөвт үйлчилгээний байгууллага байна.

4.Газар нь үйл ажиллагаандаа үндсэн хууль, бусад холбогдох хууль тогтоомж, Засаг даргын захирамж болон энэхүү дүрмийг удирдлага болгоно.

5.Аймгийн Засаг дарга нь ОНӨНҮҮГ-ын даргыг томилох буюу чөлөөлнө. Дарга нь төрийн үйлчилгээний ажлын зорилт чиг үүргийн хэрэгжилтийг аймгийн Засаг даргын өмнө хариуцаж тайлагнах бөгөөд эрх хэмжээнийхээ хүрээнд Монгол Улсын хууль тогтоомжид нийцүүлэн тушаал шийдвэр гаргана.

Хоёр. Үйл ажиллагааны зохион байгуулалт

1.Орон нутгийн өмчийн оролцоотой улсын үйлдвэрийн газар нь орон нутгийн өмчид үндэслэсэн улсын төсвөөс санхүүждэг үйлдвэрийн газар бөгөөд эд хөрөнгийн аж ахуйн тооцоотой өөрт олгогдсон эд хөрөнгийн үндсэн дээр өөрийгөө санхүүжүүлэх зарчмаар ажиллаж бие даасан иргэний гүйлгээнд орно.

2.Банкинд харилцах данстай өөрийн нэрийн өмнөөс эрх эдлэн үүрэг хүлээх хуулийн этгээд байна.

3.Үйлдвэрийн газар нь эд хөрөнгийн талаар хуульд заасан төрийн байгууллага, албан газартай нэгэн адил эрхтэй байна.

Гурав. Аж ахуйн тооцоотой ОНӨНҮ-ний үйлдвэрийн газрын захиргаа

1. Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын өдөр тутмын үйл ажиллагааг үйлдвэрийн газрын дарга удирдана.

2. Даргаар томилогдсон хүн дор дурдсан шаардлага хангасан байна.

-дээд боловсролтой, бүртгэл, санхүү эдийн засгийн болон төрийн удирдлагын мэргэжилтэй, төрийн байгууллагад 5-аас доошгүй жил ажилласан, удирдахуй ухааны дээд сургууль төгссөн бол давуу талтай, багаар ажиллах чадвартай.

3. Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын захиргааны албан тушаалын жагсаалт, орон тооны нормативыг аймгийн ИТХ-ын тэргүүлэгчид тогтооно.

4. ОНӨНҮҮГ-ын дарга нь үйлчлүүлэгч байгууллагатай байгуулсан гэрээгээр хүлээсэн үүргээ гүйцэтгэхийн тулд газрын менежер, нягтлан бодогч, бусад орон тоог баталж ажиллан тус бүртэй гэрээ байгуулж, томилж чөлөөлөх үүргийг хариуцна.

5. Газрын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээний нэгдүгээр гарын үсгийг дарга, хоёрдугаар гарын үсгийг нягтлан бодогч зурна.

6. Газар нь тогтоосон журмын дагуу өөрийн нэр бүхий тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

7. Үйлдвэрийн газар нь өөрийн үйл ажиллагаагаа бие даасан байдлаар Монгол улсын хуулийн хүрээнд эрхлэн явуулна.

8. Улсын төсвийн хөрөнгөөр бэлтгэгдэж гэрээгээр хүлээлгэж өгсөн үндсэн буюу эргэлтийн хөрөнгө аж ахуйн үйл ажиллагааны явцад бий болсон эд хөрөнгө санхүүгийн нөөц нь байгууллагын үйл ажиллагаа явуулах хөрөнгийн эх үүсвэр болно.

9. Газар нь үйл ажиллагаагаа өргөжүүлэх үүднээс холбогдох хууль тогтомжид заасны дагуу банкнаас зээл, урьдчилгаа авч болно.

10. Газрын санхүүгийн эх үүсвэр нь доорх хэлбэрээр бүрдэж, дарга захиран зарцуулна.

а. Улсын төсөв

б. орон нутгийн төсөв

в. гадаад, дотоод хандив, тусламж

г. аж ахуйн үйл ажиллагааны орлого

е. бусад

Дөрөв. Үйлчилгээний нэр төрөл

ОНӨНҮҮГ нь дээр дурдсан зорилтын хүрээнд дараах нэр төрлийн үйлчилгээг үйлчлүүлэгч байгууллагууд тэдгээрийн ажиллагсдад үзүүлнэ.

1. Албан контор /барилга, байгууламж/-ын үйлчилгээ

2. Ажлын байрны тавилга, техник хэрэгсэл, материал хангамжийн үйлчилгээ

3. Албан контор, үйлчилгээний барилга, байгууламжийн цахилгаан, дулаан, усан хангамжийн үйлчилгээ

4. Барилга байгууламжийн засвар, тохижлт, цэвэрлэгээ хийх үйлчилгээ

5. Бичиг хэрэг, бичих, хэвлэн олшруулах зэрэг үйлчилгээ

6. Холбоо мэдээллийн үйлчилгээ

22

Зургаа. Аж ахуйн тооцоотой ОНӨНҮ-ний үйлдвэрийн газрын эд хөрөнгийн эрх

1. Үл хөдлөх хөрөнгийг дүрэмд заасан үйл ажиллагааныхаа зорилгод нийцүүлэн эзэмшиж ашиглана.
2. Үндсэн хөрөнгийг хуульд заасан эрх хэмжээний дотор захиран зарцуулна.
3. Үйлдвэрийн үйл ажиллагааны үр дүнд олсон ашгаас эрх бүхий байгууллагаас баталсан нормативт хэмжээгээр өөртөө үлдээж захиран зарцуулна.
4. Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээ өөрөө бие даан борлуулах.
5. Аж ахуйн тооцоон дээр ажиллаж байгаа үйлдвэрийн газар нь үндсэн хөрөнгийг зөвхөн айгийн ИТХ орон нутгийн өмчийн албаны зөвшөөрөлтэйгээр данснаас хасах буюу борлуулах тусгай эрхтэй байна.

Долоо. ОНӨНҮҮГ-ын даргатай байгуулах гэрээний нөхцөл

1. Энэ гэрээнд заасан эрх үүрэг
2. Эдийн засгийн үр ашгийг дээшлүүлж, хүргэх түвшин
3. Техник технологийг шинэчлэх даалгавар
4. хамт олны хөдөлмөр хамгаалал, нийгмийн асуудалаар авах арга хэмжээ
5. Менежментийн бодлого
6. Даргаас болон үүргээ биелүүлэх талаар төрөөс хүлээх үүрэг
7. Удирдаж байгаа газарт нь өмчлөгчөөс олгосон эд хөрөнгө, түүний хэмжээ
8. Цалин, нэмэгдэл хөлс хуулиар заасан урамшуулал
9. Ажлын нөхцөл /унаа, холбоо зэрэг/
10. хуульд заасан эд хөрөнгийн хариуцлага
11. Гэрээний үүргийн биелэлтийг дүгнэх журам
12. хуульд харшлаагүй бусад нөхцөл
13. Дарга гэрээгээр тохиролцсон үүргээ биелүүлээгүй нь хүндэтгэн үзэх бодит шалтгаангүй бол түүнийг ажлаас халах үндэслэл болно.
14. Шаардлага гарвал дүрмэнд өөрчлөлт оруулах асуудлаар 2 тал тохиролцож ИТХ-ын тэргүүлэгчдийн хурлаар шийдвэрлүүлнэ.

Найм. Даргын эд хөрөнгийн эрх, үүрэг

1. Дарга, дараах эрх, үүрэгтэй
 - а/ тухайн үйлдвэрийн газрыг итгэмжлэлгүйгээр төлөөлөх, итгэмжлэл олгох
 - б/ үйлдвэрийн газрын нэрийн өмнөөс эд хөрөнгийг энэ гэрээ, хуульд заасан эрх хэмжээний дотор захиран зарцуулах.
 - в/ үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах.
 - г/ үйлдвэрийн газрын захиргааны бүтцийг тогтоож, албан тушаалтныг томилох, чөлөөлөх, эрх бүхий байгууллагаас тогтоосон цалингийн бүдүүвч сангийн хэмжээнд багтаан цалинг тогтоох.
 - д/ үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, технологийн нууцад хамаарах мэдээллийг тогтоох.

24

ОНӨНҮҮГАЗАР БАЙГУУЛАХТАЙ ХОЛБОГДОЖ УГ
ГАЗРЫН ТАЛААР САНАЛ БОЛОВСРУУЛАХ АЖЛЫН
ХЭСГИЙН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

Аймгийн Тамгын газрын даргын тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг 2014 оны 4 сарын 3-ны 10.00 цагт ажлын хэсгийн дарга Б.Түвшинбаярын өрөөнд эхэлж, хуралдаанд гишүүн. Г.Батжаргал, Н.Сүхбаатар, А.Цэгмэдбаатар нар оролцож, гишүүн Ц.Даваа УБ хотод ар гэрийн гачигдалтай байгаа тул оролцсонгүй.

Хуралдааныг Б.Түвшинбаяр нээж, ажлын хэсэг байгуулах тухай захирамжийг танилцуулан газар болон өөрчлөгдөх болсон нөхцөл байдал, зорилгын талаар мэдээлэв.

Ингээд Батжаргал даргын саналыг сонсоод үүн дээр тулгуурлан санал бодлоо ярьцгаая.

Г.Батжаргал: -Бид ажилчдынхаа хүрээнд хуралдаж санал бодлоо хэлэлцсэн байгаа мөн газрын хэлбэр зохион байгуулалтаар ажиллаж байгаа Өмнөговь аймгийн ОНӨНҮГ-ын дарга Машбаттай ярьж мэдээлэл авсан. Төв аймгийн НҮА-ны дарга Чинзориг гэдэг хүнтэй ярилцаж санаа бодлоо солилцсон.

Төв аймаг бол газар болоогүй НҮА хэвээр зочид буудал, гуанз, туслах аж ахуй зэрэг бизнесийн шинж чанартай үйлчилгээнүүдийг хуульд нийцүүлэн татан буулгасан байна.

Өмнөговь бол ОНӨҮ газар болсон гэхдээ үйл ажиллагаа нь төсвөөс цалинждаг орон тооныхоо хүрээнд ерөнхийдөө албаны маягаар ажиллаж байна. Төсвөөс цалинждаг 40 гаруй хүнтэй, өөрийн 2 авто машинтай юм билээ.

Санал:

1. Тамгын газрын авто машин энэ хэвээрээ байх, бид техникийн бэлэн байдал, хадгалалт, жолооч нарыг хариуцаад хуучнаараа гэсэн үг ажиллах. Парк шинэчлэлт хийх шаардлагатай, зам харилцаа сайжирч байгаа тул зардал багатай жижиг тэрэг 2, дуудлагаар явдаг 1 пургон, 1 жип машин, мэдээж дарга нарын машинууд хэвээр байна байх. ОНӨҮГ-т суудлын 1 тэрэг, бага оврын ачааны машин байх шаардлагатай байна.

2. Төрийн үйлчилгээний барилга байгууламж, объектын халаалт, гэрэл, урсгал зардал энэ хэвээр байх хэрэгтэй. Өмнөговь ч ингэж ажиллаж байна. Өөрийн гэсэн санхүү, ААН-ын хэлбэрээр ажиллах гэж байгаа газар төрийн том объектийн зардлыг хариуцаад ажиллах нөхцөл бололцоо одоохондоо мэдээж байхгүй. Цаг хугацааны дараа байдлаас шалтгаалан юмыг өөрчилж болох бизээ гэж бодож байна.

3. Төсвөөс цалинждаг орон тоог зарим үйлчилгээн дээр нэмж өгөх талаар анхаарах хэрэгтэй байна. Жишээ нь:

Үйлчлэгч 2, харуул 1, цахилгаанчин мужаан 1, ня-бо 1, нярав 1

4. ОНӨҮ газарт ямар өмч шилжүүлэн авах талаарх санал

I. "Ёслол хүндэтгэлийн өргөө" дутуу ажил, сайжруулан засах ажлуудыг өмнө нь төсөвлөж, төлөвлөж байсны дагуу хийж дуусгах. 1-р давхарыг байнгын гал тогоогоор ажиллуулж, дээд давхарыг төрийн аливаа арга хэмжээний чөлөөгөөр байгууллага, ИНБ, иргэдэд ёслол хүндэтгэл соёлын төлбөртэй арга хэмжээ явуулж орлого олох замаар ажиллана.

II. "Зочид буудал" цаашид буудлын зориулалтаар нь ажиллуулна. Тохижилт сайжруулан, байнгын ажиллагаатай үнийг зах зээлийн уян хатан байдлаар тогтоож, хүн ирэх байрлах сонирхол нөхцлийг бий болгосноор тодорхой хэмжээний орлого олох.

III. “Доод давхар гуанз” Олон хүн орох арга хэмжээнд гуазны хэлбэр, бусад үед нь хурлын заал хэлбэрээр байж болох юм, эсвэл шилэн хаалт, ханаар тусгаарлаж төрийн чиглэлийн үйлчилгээ, контор байхаар зохион байгуулж болох юм гэж төсөөлж байна.

IV. “Хурлын заалнууд” –Төрийн ажлуудыг хийх бэлтгэл зохион байгуулалтыг хангаж ажиллахаас гадна бусад цагаар байгууллага, төслийн газрууд гэх мэт бусдад төлбөртэй үйлчлэх.

V. “Ногооны талбай” –ногоо тарьж хэвших, өргөжүүлэх, дотоодын хэрэгцэнээс гадна ашиг олох. Талбайныхаа дэргэд ногооны зоорьтой болж газар тариаланг гол туслах аж ахуй болгон хөгжүүлэн ажиллана.

VI. Захын хажууд байрлах “тоосгон байшин” бичих хэргийн бэлтгэн нийлүүлэх цэг байгуулах, хэвлэл үйл ажиллагаа эрхлэх зэргээр ашиглах юм. Эхлээд зьасвар хийгээд өгчихвөл цаашид энэ объектийн зардлыг бүрэн хариуцах боломжтой гэж үзэж байна.

VII. “албан үүрэг гүйцэтгэх контор” -даргын өрөө, санхүүгийн өрөө, жолооч нарын өрөө, үйлчлэгч нарын өрөө, сантехник, цахилгаанчины өрөө

Эдгээрийн одоо хэрэглэж байгаа эд хөрөнгө, техник хэрэгсэл, бгаж төхөөрөмж

VIII. Теннисний өрөө, чийрэгжүүлэлтийн танхимуудыг энэ зориулалтаар нь ашиглах бол манайх хариу, авч ажиллуулж болох юм.

5. Газар нь дүрэмд заасны дагуу төрийн зарим чиг үүргийг хариуцан гүйцэтгэхээс гадна өөрийн өмчлөлд ирсэн объектоор бизнесийн үйл ажиллагаа явуулж ашиг орлого олж бие даах, ажиллагсадын цалин хөлс, нийгмийн хангамжийг сайжруулах боломж гэж үзэж байна.

Үйл ажиллагаа бүр дээрээ төсөв төлөвлөгөө боловсруулж, ажиллах журам эрх зүйн актуудыг боловсруулна. Өмчлөл, чиг үүрэг нэг тийшээ болоодохвол гэрчилгээгээ гаргуулах, тамга тэмдэгээ авах зэрэг дараагийн ажлууд байна.

Б.Түвшинбаяр: -Батжаргал даргын ярьсан, гаргаж байгаа санал дээр тулгуурлаад асуух, өөрсдийн саналыг хэлцгээе.

Н.Сүхбаатар: -Үйлчилгээний ажилчдын орон тоог, хойд өргөө ажилд орно гэдгээр нэмэгдүүлсэн байх ёстой, одоо харж байхад хуучин хэвээрээ ажиллаад байгаа байдаг, цалин нь байгаа гэсэн л үг дээ.

Б. Түвшинбаяр: -Төсвөөс цалин, бусад зардлыг нь шууд өгчихнө гэсэн үг үү.

А.Цэгмэдбаатар: -Цалин , НДШ өөр зардал гаргаж өгөхгүй байх. Одоо хэрэглэж байгаа техник хэрэгсэл, багаж тоног төхөөрөмжийг шилжүүлнэ.

Б.Түвшинбаяр: -захын тэндэх улаан байншинг зөвлөлийн хурлаар өөр зориулалтаар ашиглахаар болсон доо, Батжаргал даргын санал юм чинь, ингээд бид ч нэмж хасаад яриад байх юм алга даа, сайн мэдэхгүй л байна шүү. Ямарч байсан энэ яригдсан саналуудыг Цэгмэдбаатар тэмдэглэл болгож хэвлээд бэлдээдэх, тэгээд Чулуунбат даргад танилцуулья.

Тэмдэглэл хөтөлсөн

А.Цэгмэдбаатар

БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2013 оны
06-р сарын 13-ны 79 дүгээр
тогтоолын нэгдүгээр хавсралт

Төрийн үйлчилгээний мөнөжөр	Ня-бо -1	Дарга	Бизнесийн үйлчилгээний мөнөжөр
	Няраг -1		
	Архив, бичиг хэргийн ажилтан -2		
	Жолооч -7		
	Компьютер сүлжээний мэргэжилтэн -1		
	Мужаан, цахилгаанчин сантехникч -1		
	Харуул хамгаалалт -5		
	Цэвэрлэгээ үйлчилгээ -6		
	Буудлын эрхлэгч, үйлчлэгч -2		
	Цайны газар -4		
	Харуул хамгаалалт -2		
	Жолооч -2		
	Цэвэрлэгээ үйлчлгээ -2		
	Туслах ажилчид -2		
	Түр ажилчид		